



ЭХ ОРОНЧДЫН
НЭГДСЭН НАМ

БАГА ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 4 сарын 30 дөр

Дугаар 02

Улаанбаатар

Эх орончдын нэгдсэн намын 2012 оны Улсын Их Хурлын
сонгуулийн мөрийн хөтөлбөрийг батлах тухай

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1, 23 дугаар зүйлийн 23.4.3, Эх орончдын нэгдсэн намын дүрмийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Бага хурлын төлөөлөгчдийн 100 хувийн саналаар Эх орончдын нэгдсэн намын 2012 оны Улсын Их Хурлын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг баталсугай.
2. Үндэсний Аудитийн газрын дүгнэлтийг үндэслэн мөрийн хөтөлбөрт өөрчлөлт оруулах бол хэлэлцэн шийдвэрлэхийг намын Удирдах зөвлөлд зөвшөөрсүгэй.



/Г.Ганбат/

/С.Тулга/



ЭХ ОРОНЧДЫН
НЭГДСЭН НАМ

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2012 оны 5 сарын 4 өдөр

Дугаар 04

Улаанбаатар

Эх орончдын нэгдсэн намын 2012 оны Улсын Их Хурлын сонгуулийн мөрийн хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4, 34 дүгээр зүйлийн 34.5, Үндэсний Аудитийн газрын 2012 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн албан тоот, Эх орончдын нэгдсэн намын Бага хурлын 2012 оны 4 дүгээр сарын 30-ний өдрийн 04 тоот тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Үндэсний Аудитийн газраас ирүүлсэн дүгнэлтэд Эх орончдын нэгдсэн намын 2012 оны Улсын Их Хурлын сонгуулийн мөрийн хөтөлбөрийн 2.13, 3.10, 3.11 заалтууд Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.3, 34.4 заалтыг хангаагүй гэсэн дүгнэлт гарсан байх тул тус мөрийн хөтөлбөрийн 2.13 дугаар заалтыг бүрэн хасч, 3.10, 3.11 заалтыг хуульд нийцүүлэн нэгтгэн “Төрөлт буурч, гэр бүл салалт өсч, хүүхдийн хөгжил саатаж буй сөрөг үзэгдлийг бууруулах зорилгоор хүүхэд төрүүлсэн эх, нэн ядуу өрхийн болон гадаадад ажиллаж байгаа иргэдийн хүүхдүүдэд чиглэсэн улс төрийн шийдэлтэй тодорхой нийгмийн хамгааллын бодлогыг дэвшүүлнэ” гэж өөрчлөн найруулсугай.
2. Энэхүү мөрийн хөтөлбөрийг Сонгуулийн Ерөнхий хороонд хүргүүлэхийг намын нарийн бичгийн дарга /С.Тулга/-д даалгасугай.



Удирдах зөвлөлийн дарга

Г.Ганбат



2012 оны 04 дугаар сарын 30-ны
өдрийн Эх орончдын нэгдсэн намын Бага
хурлаас батлав.

Эх орончдын нэгдсэн намын

2012 оны УИХ-ын сонгуулийн мөрийн хөтөлбөр

Монголын эх орончид эвлэлдэн нэгдэж, сонгуулийн хувьсгалаар эх оронч төрөө цогцлоож, улс,үндэстнийхээ язгуур эрх ашгийг дээдэлсэн эх оронч бодлого баримтална гэсэн намынхаа амин үзэл санааг хэрэгжүүлэх зорилго өвөртлөн 2012 оны УИХ-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрөө дэвшүүлж байна. Бид ардчилал,шударга ёсны зарчимтай, үндэсний тусгаар тогтнол, бүрэн эрх, эв нэгдлийг сахин хамгаалагч, хүний эрх, эрх чөлөө, тэгш байдлыг хэрэгжүүлэгч, чөлөөт ардчилсан үзэл баримтлал бүхий нийгэмд нээлттэй баруун төвийн намын хувьд өнөөгийн улс төр,нийгэм, эдийн засаг,эрх зүйн хямрал, байгаль орчны сүйрэл, шударга ёсны гажуудал, ардчиллын мухардал,сэтгэлгээний хоцрогдлыг засахад Монгол Улсад зарчмын цоо шинэ хандлага буюу хувьсгалт өөрчлөлт шинэчлэлт шаардлагатай гэж үзнэ.

Зорилт 1. ТӨРИЙН ТОГТОЛЦООНЫ ХУВЬСГАЛ

Ардчилсан сонгуулиар байгуулагдаж, хүлээн зөвшөөрөгдсөн, ямагт улс, үндэстнийхээ язгуур эрх ашгийг дээдэлсэн эх оронч бодлого хэрэгжүүлэх, шударга ёсыг сахин хамгаалагч, эрхийн чадамж,үүргийн хариуцлагатай, иргэддээ үйлчилдэг, үйл ажиллагаа нь тунгалаг, нээлттэй сайн засаглалыг тогтоож, ард түмнийхээ төрдөө итгэх итгэлийг сэргээнэ.Үүнд:

- 1.1 Парламентын засаглалыг төгөлдөршүүлж, Улсын Их Хурал, Улсын Бага Хурал гэсэн 2 танхимт тогтолцоонд шилжүүлнэ.
- 1.2 Ерөнхий сайдаас бусад Засгийн газрын гишүүд парламентын гишүүн байхыг хориглоно.
- 1.3 Ерөнхийлөгчийг УИХ-аас сонгодог болгоно.
- 1.4 Бүх шатны шүүгчдийг иргэд шууд сонгох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 1.5 Бүх шатны Засаг даргыг иргэд шууд сонгож, Иргэдийн хурал нь батламжилдаг эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 1.6 Үндэсний аудитын газрын дарга, Авилгатай тэмцэх газрын дарга нарыг парламентын цөөнхөөс, Улсын Ерөнхий прокурорыг парламентын олонхиос нэр дэвшүүлж,парламент батлахаар хуульчилна.
- 1.7 Засгийн газрын бүтцэд Үндэсний хөгжлийн яам байгуулж,шинжлэх ухааны судалгаа, шинжилгээнд суурилсан урт, дунд, богино хугацааны хөгжлийн стратеги хэрэгжүүлнэ.
- 1.8 Засгийн газрын тохируулагч агентлаг Үнэ, стандартын хороог байгуулж, хэрэглээний үнийн зах зээлийн судалгаа,жишиг үнийг нэгдмэл байдлаар

гаргаснаар үнийн монополи, тендер, худалдан авалтын луйварыг арилгаж, гааль, татварын ажлыг хөнгөвчилнө.

- 1.9 Намуудыг хатуу гишүүнчлэлтэй байх, хандив, тусламж авах, үл хөдлөх хөрөнгө эзэмших, төрийн албаны үйл ажиллагаанд аливаа хэлбэрээр хутгалдахыг хатуу хориглож, дэмжигчдийн статустай, бүх шатны сонгуульд авсан суудлын тоогоор төсвөөс санхүүждэг, байрны хангамж эдэлдэг, улс орны хөгжлийн бодлого боловсруулж улс төрийн аргаар хэрэгжүүлдэг институц байхаар хуульчилж, дахин бүртгэл явуулна.
- 1.10 Төрийн улс төрийн албан хаагч, төрийн захиргааны албан хаагч, төрийн тусгай албан хаагч, төрийн үйлчилгээний албан хаагчийн эрх зүйн байдлын тухай багц хуулийг батлан гаргаж, тухайн төрийн алба бүрийн шалгуур үзүүлэлт, стандарт, эдлэх эрх, үүрэг, хариуцлага, хангамж, карьерийн зарчмыг нягт тусган хэрэгжүүлэх бөгөөд хуулийн дагуу дахин аттестатчлал явуулна.
- 1.11 Төрийн албаны зөвлөлийн статусыг олон нийтийн байхаар өөрчилж, зөвлөлийн бүрэлдэхүүнд төрд татвар төлдөг, төрөөр үйлчлүүлдэг байгууллага, иргэний нийгэм, иргэдийн төлөөллийг тэнцвэртэй, өргөн хүрээтэй оролцуулж, нийгэм, олон нийтийн хяналтын механизмыг төлөвшүүлнэ.

Зорилт 2. ЭДИЙН ЗАСГИЙН БҮТЦИЙН ХУВЬСГАЛ

Үндэсний эдийн засгийн тусгаар тогтнол, аюулгүй байдлыг бэхжүүлж, олон тулгуурт, хөрвөх чадвартай, мэдлэгт суурилсан, хүчирхэг бүтцийн үндсийг бүрдүүлж, түүний үр өгөөжийг монгол хүн бүр шударгаар хүртэх боломжийг олгоно. Дан ганц уул уурхайн өсөлтөөс хамааралтай эдийн засгийн гажуудлыг засч, тэндээс бий болсон хуримтлалыг хөдөө аж ахуй, ашигт малтмалын бүтээгдхүүнийг боловсруулах, үйлдвэрлэх, аж үйлдвэрийн парк байгуулах, инновацийг нэвтрүүлэх, цахим программ үйлдвэрлэх, өндөр технологи нутагшуулах бизнес инкубацийн төвүүдийг нээх, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чиглэсэн бодлогыг тууштай хэрэгжүүлнэ. Үүнд:

А.Төсөв, санхүү

- 2.1 Төсвийн хэмнэлтийн бодлого хэрэгжүүлж, бүтээснээсээ илүү хэрэглэхгүй байх зарчмыг баримтлана.
- 2.2 Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсвийн зарлагыг УИХ-аас нэмэгдүүлэн батлахыг хориглоно.
- 2.3 УИХ-аас татварын болон татварын өршөөл, хөнгөлөлтийн тухай хууль, Засгийн газраас татварын өршөөлийн хууль санаачлахыг хориглоно.
- 2.4 Төгрөгийн худалдан авах чадварыг дээшлүүлэх, ханшийг чангаруулах бодлого барина.

- 2.5 Инфляцийн өсөлттэй уялдуулан цалин, тэтгэвэр, тэтгэмжийг тогтмол индексжүүлнэ.
- 2.6 Төрийн нэрээр авах гадаадын улс, олон улсын байгууллагын төслийн зээлийг түүний нөхцөл, үр өгөөжийг харгалзан шийдвэрлэх зарчимд шилжиж, бага хүүтэй, удаан хугацаатай, аливаа нөхцөл болзолгүй, зайлшгүй хэрэгцээт арилжааны зээлийг авахыг дэмжинэ.
- 2.7 Засгийн газрын тусгай сангуудын менежментийг төсөвт байгууллагаас тусгаарлаж, бие даалгах чиглэл барина.
- 2.8 Монгол Улсын үндэсний нийт баялгыг үнэлж, эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцлийг бүрдүүлнэ.
- 2.9 Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийг шинэчилж, хөрөнгө оруулалтын төрөл, хэлбэр, онцлог, хэмжээ, эдийн засгийн үр өгөөж, ашгийн урсгал, байршил, дахин хөрөнгө оруулалт, түүний өсөлт зэргийг харгалзан аливаа хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулдаг болно.
- 2.10 Үндэсний хөрөнгө оруулагчид ижил нөхцөл олгож, тэднийг аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг хориглоно.
- 2.11 Үнэт цаасны зах зээлийн хөгжлийг гүнзгийрүүлж Хөрөнгийн биржийн үйл ажиллагааг дэлхийн стандартад ойртуулж иргэд сонирхсон хувьцаагаа чөлөөтэй арилжих, эзэмших нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.12 Моргейжийн зээлийн боломжийг өргөжүүлж, малчид, гадаадад ажилладаг иргэд, залуу гэр бүл хамрагдах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.13 Төрийн болон орон нутгийн өмчийн хувьчлалыг эрчимжүүлнэ.

Б. Байгалийн баялаг

- 2.14 Ашигт малтмалын төрөл, ордын нөөцийг харгалзахгүйгээр байгалийн баялаг ард түмний өмч гэж үзэж, төр 51-ээс доошгүй хувийг эзэмших эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 2.15 Монголын уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн үнэлгээг сайжруулахад онцгой анхаарч, үнийн нэгдсэн бодлого зохицуулалт хийнэ.
- 2.16 Монгол Улсын Засгийн газарт мэдэгдэлгүйгээр олон улсын зах зээлд монголын баялгийг барьцаалан хөрөнгө босгох, зөвшөөрөлгүйгээр эрх шилжүүлэх, худалдахыг хориглоно.
- 2.17 Үндэсний эрх ашигт харшилсан олон улсын гэрээ, хэлцлүүдийг дахин хянаж, хамтрагч этгээдтэй хэлэлцэн, засч залруулах, сайжруулах арга хэмжээ авна.
- 2.18 Улсын төсвийн хөрөнгөөр эрэл хайгуул хийсэн болон стратегийн орд газруудын хууль бусаар олгогдсон лицензийг цуцалж, буруутай этгээдүүдэд хариуцлага тооцуулна.
- 2.19 Нөөц нь тогтоогдсон ордуудыг дахин нягталж, стратегийн ордод хамруулах эсэхийг шийдвэрлэнэ.

- 2.20 Дархан цаазат газар, төрийн тусгай хамгаалалттай газар, хилийн бүс, төв суурин газар хамруулан олгосон лицензийг цуцалж, малчдын хаваржаа, өвөлжөө, шандны эх, оршуулгын газрыг тусгай зөвшөөрлөөс хэсэгчлэн чөлөөлүүлнэ.
- 2.21 Байгалийн баялгийг өвөг дээдсийн буян, өнөө бидний хишиг, үр хойчийн өмч хэмээн үзэж, УИХ-ын дэргэд улсын төсвөөс ангид Үндэсний нөөцийн сан байгуулж, ашигт малтмалын татвар, хураамжаас бусад бүх орлогыг төвлөрүүлэн ирээдүйд хадгална.
- 2.22 Үндэсний нөөцийн санг бүрдүүлэх, хадгалах, захиран зарцуулах журмыг хуулиар зохицуулах бөгөөд улсын төсвийн санхүүжилтэд тус сангаас жил бүр 10 хүртэл хувиар зарцуулахыг зөвхөн УИХ хэлэлцэн шийдвэрлэнэ.
- 2.23 Ашигт малтмал олборлогч бүх аж ахуйн нэгж өмчийн хэлбэр харгалзахгүйгээр жил бүр Үндэсний нөөцийн санд уул уурхайн бүтээгдэхүүн борлуулсан ашгийн 10 хувийг төвлөрүүлэхээр хуульчилна.

В. Үйлдвэржүүлэлт

- 2.24 Газрын тос боловсруулах үйлдвэрийг үндэсний болон гадаадын хөрөнгө оруулалтаар байгуулж, түүнийг түшиглэн нефть химийн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
- 2.25 Зэс, төмөр, бусад металлын хүдэр боловсруулах үйлдвэрийг хувийн хэвшлийн хөрөнгөөр байгуулахыг татвар, зээлийн бодлогоор дэмжиж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилтыг хэрэгжүүлнэ.
- 2.26 Тавантолгойн төслийг хэрэгжүүлэх эрхийг үндэсний хөрөнгө оруулагчдад давуу эрхээр олгож, кокс химийн үйлдвэр барина.
- 2.27 Дархан, Сайншандын аж үйлдвэрийн паркийг ашиглалтад оруулна.
- 2.28 Алтанбулаг, Замын-Үүдийн чөлөөт бүсийн үйл ажиллагааг эхлүүлнэ.
- 2.29 Техникийн их сургуулийн Налайх дахь сургалтын баазыг түшиглэн Шинжлэх ухааны академийн оролцоотойгоор инновацийг нэвтрүүлэх, өндөр технологи нутагшуулах, цахим программ үйлдвэрлэх үндэсний Бизнес инкубацийн төв байгуулна.
- 2.30 Жижиг, дунд үйлдвэрлэл, бизнесийн бүртгэл, тусгай зөвшөөрлийг хялбарчилж, татвар, зээлийн бодлогоор туслан дэмжиж, тоног төхөөрөмж, шинэ технологийг лизинг, хөнгөлттэй үнээр нийлүүлдэг таатай орчин бүрдүүлнэ.

Г. Хотжилт

- 2.28 Нийслэл Улаанбаатар хотын төлөвлөлтийг шинэчилж, эрх зүйн таатай нөхцөлтэй дагуул хотуудаар тэлэх бодлого баримтлана.

2.29 Улаанбаатар, Дархан, Эрдэнэтээс гадна баруун бүсэд Хархорин, зүүн бүсэд Өндөрхаан, говийн бүсэд Даланзадгад хотуудыг байгуулж, үйлдвэр, аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

2.30 Үндэсний уламжлал, түүх ёс заншлыг сэргээх үйлстэй уялдуулан аялал зуучлалын бодлогыг хэрэгжүүлж, аялал жуулчлалын тусгай бүс, цогцолбор газруудыг байгуулна.

Д. Дэд бүтэц

2.30 Босоо тэнхлэгийн төмөр замыг барьж дуусгана.

2.31 Улаанбаатар хотыг тойруулан 2 урсгалтай төмөр зам барих төслийг эхлүүлнэ.

2.32 Улаанбаатар хотын авто замыг бүрэн шинэчилж, замын ачааллыг бууруулахад чиглэсэн давхар зам, гүүр, гүүрэн гарц барих төслүүдийг концессоор шийдвэрлэхийг дэмжинэ.

2.33 Мянганы замын төслийг үргэлжлүүлж, бүх аймгийн төв, суурьшлын шинэ бүсүүдийг хатуу хучилттай замаар холбож дуусгана.

2.34 Нийслэл, аймгийн төвүүдийн гэр хорооллын дэд бүтцийг хөгжүүлнэ.

2.35 Хот, суурин газрын нийтийн тээврийн асуудлыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар бүрэн шийдвэрлэнэ.

2.36 Дулааны 5 дугаар станцыг Багануурын уурхайг, дулааны 6 дугаар станцыг Шивээ овоогийн уурхайг түшиглэн барина.

Зорилт 3. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХУВЬСГАЛ

Хавтгайрсан нийгмийн халамжийн бодлогыг цэгцэлж, халамжийн оновчтой, даатгалын хүртээмжтэй, хөдөлмөр эрхлэлтийн хүчтэй бодлого явуулна. Хүний хөгжлийн голлох хүчин зүйлс эрүүл мэнд, боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын асуудлыг төрийн бодлогын төвд байлгана.

А. Нийгмийн хамгаалал: халамж, даатгал, улс төрийн шийдэл

3.1 Нийгмийн халамжийг зөвхөн хөдөлмөр эрхлэх чадваргүй эмзэг хэсэг, зорилтот бүлэгт чиглүүлж, төвлөрлийг сааруулах бодлогоор орон нутагт эрх мэдэл, үйлчилгээг шилжүүлнэ.

3.2 Нийгмийн халамжийн сангийн менежментийг орон нутагт шилжүүлнэ.

3.3 Нийгмийн даатгалын хэлбэр төрлийг нэмэгдүүлнэ.

3.4 Нийгмийн даатгалын хөрөнгийг төсвийн санхүүжилтэд ашиглахыг хориглож, менежментийг бие даасан, хараат бусаар явуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

3.5 Эрүүл мэндийн даатгалыг бие даасан тогтолцоонд шилжүүлнэ.

3.6 Давхар даатгалын тогтолцоог нэвтрүүлнэ.

3.7 Гадаадад ажиллаж, амьдардаг болон хүндэтгэх шалтгаантай иргэдэд нийгмийн даатгалаа нөхөн төлөх эрх зүйн боломжийг нээнэ.

3.8 Өндөр зардалтай эмчилгээг эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулж, нөхөн төлбөрийн хэмжээг нэмэгдүүлнэ.

3.9 Нийгмийн даатгал нь тасарсан иргэдэд нэг удаа нөхөн төлөх боломж олгоно.

3.10 Төрөлт буурч, гэр бүл салалт өсч, хүүхдийн хөгжил саатаж буй сөрөг үзэгдлийг бууруулах зорилгоор хүүхэд төрүүлсэн эх, нэн ядуу өрхийн болон гадаадад ажиллаж байгаа иргэдийн хүүхдүүдэд чиглэсэн улс төрийн шийдэлтэй тодорхой нийгмийн хамгааллын бодлогыг дэвшүүлнэ.

Б.Хөдөлмөр эрхлэлт

3.11 Хөдөлмөрийн насны буюу эдийн засгийн идэвхтэй хүн амын хөдөлмөрлөх эрхийг баталгаажуулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогоор идэвхжүүлж, зайлшгүй хөдөлмөрлөх нөхцөл, боломжоор хангана.

3.12 Нэн ядуу хөдөлмөрийн насны иргэдийн ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг төр хариуцаж, ажилгүйдлийн даатгалын санг бүрэн бүрдүүлэх замаар ажилгүй иргэдийг ажилтай болох хугацааны тэтгэмж олгодог чадавхийг бий болгоно.

3.13 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

В.Боловсрол, соёл, шинжлэх ухаан

3.14 Ерөнхий боловсролын тогтолцоог Кембрижийн стандартад нийцүүлэн хөгжүүлнэ.

3.15 Зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн үндэсний мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх материаллаг болон оюуны нөөцийг бүрдүүлнэ.

3.16 Их, дээд боловсролын тогтолцоог дэлхийн жишигт хүргэх, өрсөлдөх чадвартай болгох бодлогыг хэрэгжүүлнэ.

3.17 Албан бус сургалт, зайн сургалт, түр сургалтын хэлбэрүүдийг зэрэгцүүлэн хөгжүүлнэ.

3.18 Үндэсний соёл, урлагаар дамжуулан үндэсний бахархлыг төлөвшүүлнэ.

3.19 Шинжлэх ухааны үнэлэмжийг дээшлүүлж, шинэ нээлт, бүтээлийг урамшуулж, амьдралд нэвтрүүлэхэд төрөөс дэмжинэ.

Г.Эрүүл мэнд

3.20 Эрүүл монгол хүн төслийг 4 жил тутам хэрэгжүүлнэ.

3.21 Улаанбаатар, бүсийн төвүүдэд орчин үеийн эмчилгээ оношлогооны төв байгуулна.

3.22 Өмчийн хэлбэрээс үл харгалзан эмнэлгүүдэд Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт олгоно.

Зорилт 4. НОГООН ХУВЬСГАЛ

Хүрээлэн буй орчноо хамгаалах, байгалийн нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн нийгэм, эдийн засаг, экологийн цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.1 Цөмийн эрчим хүчийг шинжлэх ухаан, эмчилгээний чиглэлээс өөр зориулалтаар ашиглахыг хориглоно.

4.2 Нар, ус, салхи зэрэг байгалийн нөхөн сэргээгдэх эрчим хүчийг ашиглахыг төрөөс онцгойлон дэмжинэ.

4.3 Үйлдвэрлэлийн зориулалтаар гүний ус ашиглахыг хориглоно.

4.4 Ой, усны нөөц ашигласны төлбөрийг нэмэгдүүлж, тэдгээрийг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулна.

4.5 Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хүн ам төвлөрсөн хот суурин газруудад шийдвэрлэж, төрөөс татвар, зээлийн бодлогоор урамшуулна.

4.6 Ой, рашаан булаг хамгаалсан, өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээсэн иргэн, хуулийн этгээдийг төрөөс урамшуулна.

4.7 Нэн ховордсон ан амьтныг хамгаалах, ургамлыг нөхөн сэргээх тэдгээрийг дахин нутагшуулах эрх зүй, эдийн засгийн үндсийг бүрдүүлнэ.

4.8 Цөлжилт, хөрсний эвдрэл, түйрэн, элсний нүүдэлтэй тэмцэх зорилгоор ойг нөхөн сэргээх, говь, хээрийн бүсэд ногоон зурвас байгуулна.

4.9 Хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх арга технологиор ашигт малтмал олборлох, уул уурхайн үйлдвэрлэл явуулахыг хуулиар хориглоно.

4.10 Иргэдийн эрүүл аюулгүй орчин, хүнсний аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор гаалийн болон мэргэжлийн хяналтын лабораторын хүчин чадлыг нэмэгдүүлж, хүнс болон байгал орчны хянан шинжилгээг тогтмол явуулна.

Зорилт 5. ШУДАРГА ЁСНЫ ХУВЬСГАЛ

Авилгыг устгах, шударга ёсыг хамгаалах бодлогыг үндсэн зарчмаа болгоно. Ардчиллын үнэт зүйлс, хүний эрх, эрх чөлөөг баталгаатай сахин хамгаална.

5.1 Авилгын хэргийг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдал, учруулсан хор уршиг, хохирлын хэмжээг харгалзан ялын ялгавартай бодлого баримтлана.

5.2 Авилгаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, авилгыг үл тэвчих орчныг бүрдүүлнэ.

5.3 Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулж, ялын бодлогыг ялгамжтай, уян хатан болгоно.

5.3 Гэрчийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

5.4 Хууль, хяналтын байгууллагын эрх зүйн байдал, тогтолцооны шинэчлэлийг гүнзгийрүүлнэ.

5.5 Хэвлэл мэдээллийн хэрэгслийг олон нийтийн болгох эрх зүйн үндсийг бүрдүүлнэ.


5.6 Үзэл бодлоор ялгаварлах, хавчин гадуурхах, мөрдөн мөшгих аливаа илрэлтэй хатуу тэмцэнэ.

5.7 Төрийн албаны хариуцлагын тогтолцоог төлөвшүүлнэ.

5.8 Төрийн шагналын системийг хална.

Намын дарга

Намын нарийн бичгийн дарга



Г. Ганбат

С. Тулга